

**"ТОГТООЛЫН ХАВСРАЛТЫГ ШИНЭЧЛЭН БАТЛАХ ТУХАЙ"
УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛЫН ТӨСЛИЙГ ХЭЛЭЛЦЭХ
ЭСЭХ ТАЛААРХ ЭДИЙН ЗАСГИЙН БАЙНГЫН ХОРООНЫ
САНАЛ, ДҮГНЭЛТ**

2023 оны 06 дугаар
сарын 13-ны өдөр

Улаанбаатар
хот

Илтгэгч: Улсын Их Хурлын гишүүн Ч.Үнддрам

Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Засгийн газраас 2022 оны 06 дугаар сарын 17-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн "Тогтоолын хавсралтыг шинэчлэн батлах тухай" Улсын Их Хурлын тогтоолын төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэх эсэх асуудлыг Эдийн засгийн байнгын хороо 2023 оны 06 дугаар сарын 13-ны өдрийн хуралдаанаараа хэлэлцлээ.

Төсөл санаачлагч нь "Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл батлах тухай" Улсын Их Хурлын 2020 оны 23 дугаар тогтоолын 2 дугаар хавсралтаар баталсан "Монгол Улсын 2021-2025 оны хөрөнгө оруулалтын хөтөлбөр"-т туссан төсөл, арга хэмжээний хэрэгжилт Коронавируст халдварт /КОВИД-19/-ын цар тахалтай холбоотойгоор удаашрах, санхүүжилт саатах зэрэг хүндрэлүүд үүссэн тул санхүүжилтийн эх үүсвэрийг шийдвэрлэх, санхүүжилтийн дүнг өөрчлөх, зарим төсөл, арга хэмжээний байршил, төсөвт өртөг, санхүүжилтийн эх үүсвэр, хуваарь болон хүрэх үр дүн, шалгуур үзүүлэлтүүд зэргийг үүссэн нөхцөл байдалд нийцүүлэн өөрчлөлт оруулах зорилгоор тогтоолын төслийг боловсруулсан байна.

Тогтоолын төслийг d.parliament.mn цахим сайтад байршуулж, иргэд, олон нийтийн саналыг авч байгаа болно.

Байнгын хорооны хуралдаанаар тогтоолын төслийг хэлэлцэх үед төсөл санаачлагчийн зүгээс тус төслийг өргөн барих үеийн цар тахлын нөхцөл байдал өөрчлөгдсөн, Өрийн удирдлагын тухай болон Хөгжлийн бодлого төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулиудад заасан шинээр зээллэгт үүсгэхтэй холбоотой зохицуулалтууд өөрчлөгдсөн зэргээс шалтгаалан "Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл батлах тухай" Улсын Их Хурлын 2020 оны 23 дугаар тогтоолын 2 дугаар хавсралтаар баталсан "Монгол Улсын 2021-2025 оны хөрөнгө оруулалтын хөтөлбөр"-ийг шинэчлэн батлах зорилго ач холбогдолгүй болсон талаар танилцуулгадаа дурдсан тул Улсын Их Хурлын гишүүд асуулт асууж, санал хэлээгүй бөгөөд дээрх тогтоолын төслийг үзэл баримтлалын хүрээнд дэмжих эсэх асуудлаар санал хураалт явуулахад Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 36 дугаар зүйлийн 36.5 дахь хэсгийг үндэслэн хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дээрх тогтоолын төслийн үзэл баримтлалыг дэмжих боломжгүй гэж үзлээ.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

"Тогтоолын хавсралтыг шинэчлэн батлах тухай" Улсын Их Хурлын

Тогтоолын төслийг хэлэлцэх эсэх талаарх Эдийн засгийн байнгын хорооны санал,
дүгнэлтийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг Та бүхнээс хүсье.

Анхаарал тавьсанд баярлалаа.

ХУРАЛДААН ДАРГАЛАГЧ:
УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН

Ж.БАТ-ЭРДЭНЭ

